

<b>1. Төслийн товч танилцуулга</b>	<b>2</b>
Уурхайн жилийн хүчин чадал	3
Уурхайн ажиллах горим	3
Төсөл хэрэгжих талбайн физик газарзүй нөхцөл	3
Уур амьсгал	4
Салхи	4
Нарны цацраг	4
Агаарын чийгшил	4
Геологийн тогтоц	4
Хайганы ФМХТ-аар	5
Хайрганы ФМБТ-аар	5
Шигшсэн элсний ФМБТ-аар	5
Ургамлан нөмрөг	7
<b>2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт</b>	<b>8</b>
<b>3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт</b>	<b>11</b>
<b>А. Байгаль хамгаалах төлөвлөгөөний биелэлт</b>	<b>12</b>
I. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	13
II. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	166
III. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	177
IV. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	18
V. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	19
<b>В. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлт</b>	<b>200</b>
VI. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	211
Хавсралт	23

## 1. Төслийн товч танилцуулга

**Төсөл хэрэгжүүлэгч:** “Суурь хана” ХХК

**Төслийн нэр:** “Тансаг хайрга” нэртэй элс, хайрганы орд ил аргаар ашиглах төсөл

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** УБ хот, Хан-Уул дүүрэг 13-р хороо Гишүүний амны орчим

**Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл:**

Манай компаний эзэмшдэг MV-010663 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй талбай дахь Гишүүний амны “Тансаг хайрга” нэртэй элс, хайрганы орд нь Төв аймгийн Алтанбулаг сумын төвөөс 21 км, Улаанбаатар хотоос 35 км, хуучин Шувуун фабрикаас хойш 5 км, Туул голын эргээс 2.1 км зайд оршино. Талбайн тусгай зөвшөөрлийн дугаар, байршлын солбицол, талбайн хэмжээг хүснэгт №1-д үзүүлэв.

**Хүснэгт 1. Төслийн талбайн байршил**

Талбайн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн хэмжээ	Олгосон он
	<b>MV-010663</b>	<b>19.94 га</b>	<b>2007-02-12</b>
<b>Гишүүний амны "Тансаг хайрга" нэртэй элс, хайрганы хольцын орд</b>	1	106° 30' 21.31"	47° 46' 46.33"
	2	106° 30' 21.31"	47° 47' 00.77"
	3	106° 30' 36.30"	47° 47' 00.77"
	4	106° 31' 01.31"	47° 47' 00.77"
	5	106° 31' 01.31"	47° 46' 59.37"
	6	106° 31' 00.15"	47° 46' 48.23"
	7	106° 30' 42.35"	47° 46' 55.52"
	8	106° 30' 30.29"	47° 46' 47.64"
	9	106° 30' 27.36"	47° 46' 46.47"
	<b>10</b>	<b>106° 30' 27.36"</b>	<b>47° 46' 46.33"</b>

### Уурхайн жилийн хүчин чадал

Хүснэгт 2. Ашиглалтын саруудад элс-хайрга олборлолтын хэмжээ

Ашиглалтын сар	Уулын цул	
	мян.м <sup>3</sup>	мян.тн
Хэмжих нэгж		
4-р сар	5.0	13.35
5-р сар	5.0	13.35
6-р сар	5.0	13.35
7-р сар	5.0	13.35
8-р сар	5.0	13.35
9-р сар	5.0	13.35
10-р сар	5.0	13.35
<b>Нийт</b>	<b>35.0</b>	<b>93.35</b>

### Уурхайн ажиллах горим

Хүснэгт 3. Ил уурхайн ажиллах горим, хугацаа

Жилийн сарууд	Календар хоног	Амралт, сул зогсолт, хон					Ажиллах хоног	Ил уурхайд ажиллах ээлжийн тоо	Ажиллах хугацаа, цаг
		баяр ёслол	цаг агаар	хангамж	амралт	технологийн			
1		0	0	0	0	0	0	0	0
2		0	0	0	0	0	0	0	0
3		0	0	0	0	0	0	0	0
4	30	0	0	0	2	0	28	1	300
5	31	0	0	0	2	0	29	1	288
6	31	1	0	0	3	0	28	1	276
7	31	5	2	0	5	0	26	1	252
8	31	0	2	0	2	0	29	1	300
9	30	1	2	3	3	0	27	1	240
10	31	0	2	0	2	0	29	1	252
11	0	0	0	0	0	0	0	0	0
12		0	0	0	0	0	0	0	0
Жилд	215	9	8	9	19	0	196	1	2124

### Төсөл хэрэгжих талбайн физик газарзүй нөхцөл

Газарзүйн хувьд уг орд нь Хэнтийн уулархаг мужийн баруун урд хэсэгт хамаарагдах бөгөөд, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Усан шүлжээний хувьд Туул гол, түүний цутгалуудаас бүрдэнэ.

Орд нь Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших тул уур амьсгалын хувьд Улаанбаатар хотынхтой адил төстэй, жилийн хамгийн хүйтэн хугацаань 1, 2-р сарууд бөгөөд агаарын температур нь -20°C-аас -25°C хүрэх ба зарим тохиолдолд хааяа -42.9°C, дулаан нь 7-р сард +25°C-аас +30°C заримдаа +35°C хүрнэ. Хөрсний хөлдөлтийн гүн нь дундажаар 3.0-4.0м-т хэлбэлзэнэ.

Энэ бүс нутагт салхи ихэнхдээ баруун, баруун хойноос чиглэлтэй бөгөөд хурд нь гол төлөв 1-5 м/сек орчим байна.

### Уур амьсгал

Улаанбаатар хот нь Богд уулын ард, Туул голын хөндийд эргэн тойрон Баянзүрх, Богдхан, Сонгино хайрхан, Чингэлтэй уулсаар хүрээлэгдсэн, Туул голын хөндий, уулсын хоорондох хотгорт байрласан тул хаалт, хотгор гүдгэрийн нөлөө их байна. Мөн нийслэл хотын бичил уур амьсгал бүрэлдэхэд дэвсгэр гадаргын болон хүний үйл ажиллагаатай холбоотой нөлөөлөл маш их байна. УБ хот орчимд байгалийн унаган төрхөө алдаж, дэвсгэр гадаргын оронд байшингийн дээвэр, хатуу хучилттай зам, машины зогсоол, цардмал талбай буй болсон байдаг. Мөн том том байшин барилгууд, муруй тахир гудмууд нь салхи хаан, чиглэл, хурдыг нь ихээхэн өөрчилдөг байна. Хотын нөлөө температурыг дулааруулах хандлагатай байдаг.

Эх газрын эрс тэс уур амьсгалын нөхцөлөөс шалтгаалан өвөл нь харьцангуй хүйтэн, зундаа халуун байдаг. Сарын дундаж температур 1 дүгээр сард  $-27.4^{\circ}\text{C}$  ба 7 дугаар сард  $17.1^{\circ}\text{C}$  байдаг. Хамгийн өндөр температур 7 дугаар сард  $39^{\circ}\text{C}$  хүрч, 1 дүгээр сард  $-40^{\circ}\text{C}$  хүрч хүйтэрдэг байна.

### Салхи

Улаанбаатар хот орчимд салхины дундаж хурд 1.3-4.8 м/сек буюу 2.7 м/сек байдаг. Улирлын хувьд, салхины хурд хаврын улиралд 1.9-6.5 м/сек, өвлийн улиралд 0.7-2.8 м/сек, бусад улиралд 1.2-5.5 м/сек тус тус байдаг байна.

### Нарны цацраг

Улаанбаатар хотод жилийн 250-аас дээш хоног нартай байдаг. Жилийн дундаж хур тунадас 361 мм, ууршилт 325 мм буюу Улаанбаатар хот нь маш хуурай уур амьсгалтай. Дундаж чийгшил 0.36%. Буянт ухаа дахь олон жилийн дундажаас үзэхэд жилд 2816 цаг нар гийгүүлж, 12 дугаар сард 5.5-5.6 цаг өдөрт гийгүүлж, 5 дугаар сард 9.5-10 цаг нар гийгүүлдэг байна. Нийт нарны цацрагийн 40-42% нь сарнисан цацраг ба 535.3 - 599.4кВ ц/м<sup>2</sup> байдаг. Жилийн дундаж нарны цацраг 1276.7 - 1379.8 кВ ц/м<sup>2</sup>.

### Агаарын чийгшил

Улаанбаатар хотод агаарын харьцангуй чийгшил дундажаар 4.7-5.3 гПа байдаг. Агаарын чийгшил нь даралт, температураас хамаарч өөрчлөгдөх ба өвөл 0.7-2.2 гПа, зун 8.5-13.1 гПа байдаг байна. Харьцангуй чийгшил 63-68%.

### Геологийн тогтоц

Геологийн тогтоцын хувьд Гишүүний амны элс, хайрганы орд нь Туул голын хөндийн орчин үеийн аллювийн гаралтай нэг тарлийн хурдаснаас тогтоно. Ордод элс, хайрга, бул чулуун хурдас Туул голын хөндийд түүний урсгалын дагуу зүүнээс баруун тийш сунаж тогтсон байдаг. Ордыг бүрдүүлж байгаа хурдас нь бүхэлдээ голын хөндийн аллювийн хурдас болох хурдас болох элс, хайрганы хольцоос тогтох бөгөөд эдгээр нь ерөнхийдөө нэг төрлийн жигд найрлагатай саарал, шаравтар саарал өнгөтэй байна. Ордын хайгуул хийсэн хэсэг дэх элс, хайрганы хольцын дотор өөр төрлийн болон онцгой ялгарах чулуулгийн үе судлууд байхгүй.

Энэхүү ордоос зүүн зүгт 3.0-3.5 км зайд Л. Мягмарсүрэн, С. Алтангэрэл, Г. Сүхбат, Н. Нанжид, А.С.Чернышев нар 1977-1978 онд Сонгино /Гишүүний ам/-ын элс, хайрганы

ордын эрэл, хайгуулын ажлыг хийж, элс, хайрганы нөөцийг  $A+B+C_1$  зэргээр 35249.0 мян.м<sup>3</sup>,  $C_2$  зэргээр 52800.0 мян.м<sup>3</sup>-ээр тогтоож, УАМНК-оор батлуулсан ба Гишүүний амны энэхүү ордоос урагш 1.0-1.2 км-т ПНИИС гидрогеологийн 60-р цооног өрөмөдөж, энэ орчимд Туулын аллювийн элс, хайрга бүхий хурдасны зузааныг 50 метр орчим гэж тогтоожээ.

Манай компани нь 2007 онд ордын хайгуулыг 800х1200 метр талбайд 200х200 метр ба 400х400 метрийн тороор 4.3-4.5 метр, дунджаар 4.38 метрийн гүнтэй 26 малталтаар нийт 975.0м<sup>3</sup> малталт хийж, түүгээр илрүүлсэн элс, хайрганаас малталт бүрээс 1, бүгд 25 (М-25) сорьц авч, 5 мм-ийн шигшүүрээр элс (<5мм) ба (<5мм)-ны агуулгыг тодорхойлсны дараа элс, хайрга тус бүрд физик- механикийн хураангуй (ФМХТ) болон бүрэн туршилт (ФМБТ)-ыг БАК-ын барилгын материал, технологийн судалгааны төвийн Бетон дүүргэгчийн лабораторид MNS 2998; 2001, MNS 2916; 2002 стандартаар хийлгэсэн.

### Хайганы ФМХТ-аар

40-70 мм-ийн хэмжээтэй хайрганы агуулга ордын хэмжээнд дунджаар 6.06%, 20-40 мм-ийн хэмжээтэй хайрганы агуулга ордын хэмжээнд дунджаар 28.38%, 10-20 мм-ийн хэмжээтэй хайрганы агуулга ордын хэмжээнд дунджаар 52.10%, 5-10 мм-ийн хэмжээтэй хайрганы агуулга ордын хэмжээнд дунджаар 19.06%, Асгаасын нягт 1207-1719 кг/м<sup>3</sup>, шаварлаг, тоосорхог хэсгийн агуулга 0.1-0.9%, чийг 0.2-2.1%, хайрганы агуулга дунджаар 56.57%, элсний агуулга дунджаар 41.27% болохыг тогтоосон. Мөн шигшсэн элсний 2.5 мм-ийн хэмжээтэй хэсгийн агуулга ордын дунджаар 27.43%, 1.25 мм-ийн хэмжээтэй хэсгийн агуулга ордын дунджаар 15.18%, 0.63 мм-ийн хэмжээтэй хэсгийн агуулга ордын дунджаар 14.38%, 0.315 мм-ийн хэмжээтэй хэсгийн агуулга ордын дунджаар 21.72%, 0.14 мм-ийн хэмжээтэй хэсгийн агуулга ордын дунджаар 16.15%, <0.14 мм-ийн хэмжээтэй хэсгийн агуулга ордын дунджаар 5.24% байна. Элсний нягт ордын хэмжээнд 2.58-2.70 г/см<sup>3</sup>, шаварлаг, тоосорхог хэсгийн агуулга ордын хэмжээнд 0.5-2.2%, ширхэгийн модуль 1.98-4.08, асгаасын нягт 1381-1594 кг/м<sup>3</sup>, ширхэг хоорондын зай 34.0-48.3%, элсэн дэх органик хольц зөвшөөрөгдөх хэмжээнд байна. Элсний ширхэгийн модуль ордын хэмжээнд 1.98-4.08, дунджаар 2.99 (25 сорьцоос 4-д <2.5) байгаа нь энэ ордын шигшсэн эли бүдүүн ширхэгтэй (<2.5)-г харуулж буй ба хүнд бетонд хэрэглэгч дүүргэгч материалын MNS 2803; 2004 стандартын техникийн шаардлага 2.1-3.25-г хангаж байна. Элсний ширхэгийн модуль В блокод дунджаар 1.34, С блокод 1.36, ордын дунджаар 1.35 буюу ерөнхийдөө том- дунд ширхэгтэй.

### Хайрганы ФМБТ-аар

Хайрганы асгаасын нягт 1428.0 кг/м<sup>3</sup>, ширхэгийн дундаж нягт 2.67 г/см<sup>3</sup>, нягт 2.69 г/см<sup>3</sup>м, ширхэг хоорондын зай 46.5%, сүвэрхэг чанар 0.74%, бутрамтгай чанар 7.9%, нимгэн, зүүлэг хэсэг 55.2%, шаварлаг, тоосорхог хольц 0.6%, бүхэл шавар байхгүй, ус шингээлт 0.59%, органик хольц шаардлага хангана, чийглэг 1.3%, 5-10 мм-ийн хэмжээтэй фракц 50.5% байна.

### Шигшсэн элсний ФМБТ-аар

Асгаасын эзэлхүүн масс 1506.0 кг/м<sup>3</sup>, нягт 2.67 г/см<sup>3</sup>, ширхэг хоорондын зай 41.8%, шаварлаг, тоосорхог хольц 1.2%, бүхэд шавар байхгүй, ширхэгийн модуль 2.67, органик хольц- шаардлага хангана, чийглэг 1.2%, 2.5 мм-ийн хэмжээтэй хэсгийн агуулга 19.2%, 1.25 мм-ийн хэмжээтэй хэсгийн агуулга 13.00%, 0.63 мм-ийн хэмжээтэй хэсгийн агуулга 14.4%, 0.315 мм-ийн хэмжээтэй хэсгийн агуулга 29.7%, 0.14 мм-ийн хэмжээтэй хэсгийн агуулга 16.5%, <0.14 мм-ийн хэмжээтэй хэсгийн агуулга 7.2% байна.

МУИС-ын Цөмийн судалгааны төвд хийлгэсэн цацрагжил-эрүүл ахуйн үнэлгээгээр энэ ордын элс, хайрганы радийн эквивалентын дунджийг 121.7 Бк/кг гэж тодорхойлсон ба түүнийг барилгын материалд зөвшөөрөгддөг хэмжээ 370 Бк/кг-тай харьцуулахад 3.05 дахин бага байгаа юм.

Уг орд нь Улаанбаатар хотын дэргэд оршдог, дэд бүтэц сайн хөгжсөн, зам харилцаа сайтай, зах зээлдээ ойрхон, бүтээгдэхүүнээ түргэн шуурхай борлуулах боломжтой зэрэг таатай нөхцөлтэй.

Уурхайн ашиглалтын технологи нь ил аргаар тээвэрлэлттэй ашиглалтын системээр явагддаг. Ордын хөрс хуулалт, элс, хайрга олборлолт, ангилах үйлдвэр болон нөхөн сэргээлт, байгаль орчныг хамгаалах ажилд БНСУ-д үйлдвэрлэсэн HYUNDAI R300LC-9S экскаватор, БНХАУ-д үйлдвэрлэсэн XG-951, Liu Gong-ZL 50, SEM 650B маркын ачигчууд, STEYER маркын өөрөө буулгагч хүнд даацын авто машинууд зэрэг машин, механизмууд тус тус ажилладаг. Уурхайн догол, мөргөцөгийн өндөр урвуу утгуурт экскаватор ажиллаж байх үед  $h=2.5-3$  м, оролтын өргөн  $A=5-7$  м, ажлын талбайн өргөн  $Ш=30-50$  м, доголын налууугийн өнцөг  $\alpha=35-45^\circ$ , тээврийн зай 1 км, аюулгүйн зурвас  $v=1-1.5$  м байдаг. Уурхайн болон үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд хэвийн найдвартай ажиллагаатай.

Нийт 29 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн. Мөн үүний дотор нөөцөлж хураасан байсан 20000 м.куб гаран шимт хөрснөөс ашиглан 27 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж газраа үржил шимтэй хөрсөөр хучсан болно. Одоогийн байдлаар нийт ашигласан талбайн 93%-ыг үржил шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлт хийсэн бөгөөд техникийн нөхөн сэргээлтийг 100% хийсэн. Цаашид биологийн нөхөн сэргээлт хийх зорилгоор 10000 ширхэг саваа модны суулгац худалдан авсан бөгөөд эхний ээлжинд саваа модоо үржүүлж, үржүүлсэн саваа модыг нийт талбайдаа тарих зорилго тавин ажиллаж байна. Саваа модоо үржүүлэхэд зориулан 2 га талбайд 600 метр хашаа барьж бэлтгэсэн болно.

2014 онд 4 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж 3.7 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж байсан. Энэ ажлын хүрээнд нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын зөвлөмжөөр 75 кг ерхөг согооврын үрийг авч тарьсан бөгөөд байгаль орчны нөхөн сэргээлтэд нийт 18525000 төгрөг зарцуулан ажиллаж байсан. 2014 оны 5-р сард НБОНХГ-ын ХБОБНХ-ийн дарга Маратаар ахлуулсан НМХГ, Хан-Уул дүүргийн МХХ, Төрийн бус олон нийтийн байгууллагын төлөөллүүдийн бүрэлдэхүүнүүдтэй баг уурхайн олборлолт, бүтээгдэхүүн гаргалт, байгаль орчны нөхөн сэргээлтийг газар дээр нь үзэж танилуан уг ажлын хэсэг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээн авч манай компанийн гүйцэтгэсэн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг 91.6% гэж дүгнэж байсан. (Дүгнэх хуудасны хуулбарыг хавсаргав) Мөн 2014 оны 6-р сарын 20-нд Нийслэлийн МХГ, элс, хайрга, дайрга Үйлдвэрлэгч Компаниудын Холбоо хамтарч Байгаль орчны нөхөн сэргээлтийн сургалт зохион байгуулж, манай компанийн талбайд үзүүлэх сургалт хийж, нөхөн сэргээсэн талбайг үзэж санал солилцож, зөвлөгөө өгч байсан.

Ахуйн хэрэгцээний усыг худагас хангаж, уурхайн орчны хог хягдалыг цэвэрлэж хогийг Биокомбинатын хогийн цэгт хаясан.

Уурхайн эдэлбэр газрын аюулгүй байдлыг хангах зорилгоор уурхайд явган хүн орох гарах аюулгүйн налуу зам хийж ажилласан. Нийт ажиллагсадад ХАБЭА талаар өдөр бүр зааварчилгаа өгч, ажилд гаргадаг.

2022 онд уурхайн, үйлдвэрт 10 хүн ажиллаж, тэдэнд өдөр тутмын хөдөлмөр хамгаалалын зааварчлагааг тогтсол өгч, ажлын хувцас багаж хэрэгслээр бүрэн хангасан бөгөөд энэ хугацаанд үйлдвэрлэлийн осол аваар гараагүй.

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг НБОГазарт хүргүүлэв.

### Ургамлан нөмрөг

Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт байрлах талбайн ургамлын хэв шинж нь ургамал газарзүйн мужлалаар Евро-Азийн шилмүүст ой, нуга хээрийн их муж, Өвөр байгалийн дэд муж, Тууд Бархын хэв шинжид хамаарагдана<sup>1</sup>.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчидсан үнэлгээгээр төслийн талбайд талбайд уулын хээрийн бүсийн Хялгана-алаг өвс, Улалж-шарилжит бүлгэмдэл буйг илрүүлж, ургамал бүлгэмдлүүдийн өнөөгийн төлөв байдал дунд зэрэг доройтсон.

Ургамалжлын зүйлийн бүрэлдэхүүний хувьд 12 овгийн 25 төрлийн нийт 29 зүйл ургамал бүртгэгдсэн. Эдгээр ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд сөөг-1, сөөглөг-1, сөөгөнцөр-1, сөөгөнцөрлөг-2, олон наст өвс-18, хоёр наст-1, нэг наст-5 зүйл ургамал тус тус тэмдэглэгдсэн.

Судалгааны талбайд бэлчээр, тэжээлийн үнэт ургамал *Stipa sibirica*-сибирь Хялгана, *Stipa krylovii*-крыловын Хялгана, *Cleistogenes squarrosa*-дэрвээн Хазаар өвс, *Achnatherum splendens*-гялгар Дэрс, *Koeleria macrantha*-том цэцэгт Дааган сүүл, *Chloris virgata*-саваан Булган сүүл, *Allium bidentatum*-саваан Булган сүүл зэрэг ургамлууд тэмдэглэгдсэн байна.



## 2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

“СУУРЬ ХАНА” ХХК-ийн MV-010663 тоот тусгай зөвшөөрөлтэй түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох талбай нь нийт 19.94 га талбайтай бөгөөд ерөнхийдөө Чулуурхаг нимгэн хөрстэй байна.

Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн нутагт орших Тансаг элс-хайрганы ордыг ил аргаар ашиглах төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэн тогтоовол.

### Хүснэгт 4.Төслөөс байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийн матриц

Байгаль орчны үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөлөл	Эерэг нөлөөлөл
	Ил уурхайн ашиглалтын үеийн сөрөг нөлөөлөл	
<b>Экологи орчин</b>		
1. Усны гидробионт		
2. Хөрсний микроорганизм	++	
3. Амьтадын тархац нутаг	+	
<b>Физик орчны өөрчлөлт, бохирдол</b>		
4.Усны чанар, нөөц /ундны ус/		
5.Агаар орчны тоосжилт	+	
6.Хөрсний бохирдол	++	
7.Хөрсний эвдрэл, элэгдэл	+++	
8.Дуу, чимээний нөлөөлөл	+	
<b>Байгалийн нөөц, ашиглалт</b>		
9.Газар ашиглалт	+	
10. Бэлчээр	+	
11. Газар тариалан		
12. Эрдэс, түүхий эдийн нөөц	++	
<b>Байгалийн гамшиг, хүний буруутай үйл ажиллагаа</b>		
13. Үер ус, газар хөдлөл	+	
14. Байгалийн аюулт үзэгдлийн давтамж ихсэх		
15. Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй осол	+	
<b>Нийгэмд үзүүлэх нөлөөлөл</b>		
16. Эрчим хүчний хангамж		
17. Усан хангамж		
18. Шинээр ажлын байр бий болох		++
19. Бүтээн байгуулалт		+++
20. Нүүлгэн шилжүүлэх асуудал гарах эсэх		
21. Хүн амын орлого өөрчлөгдөх		+
<b>Эдийн засаг, байгаль орчин</b>		
22. Хувь хүний орлого, татварын хэмжээ өөрчлөгдөх		+
23. Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх		++
24. Ажлын байр нэмэгдэх		+
25. Ядуурлыг бууруулах		
26. Газар ашиглалт нэмэгдэх		+



<b>Байгалийн үзэсгэлэн төрх байдал</b>		
27. Байгалийн үзэмж доройтох	+	
28. Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	+	
29. Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх		
<b>Түүх, археологи, соёлын өв дурсгалт зүйл</b>		
30. Түүхийн дурсгалт зүйлд нөлөөлөх		
31. Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх		

+++ - их, ++ -дунд , + - бага зэрэг , - бага зэргийн эрчимтэйгээр нөлөөлөгүй гэж үзнэ.

Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нийт 31 үзүүлэлтийг сонгон авсанаас хөрсний микроорганизм, амьтадын тархац нутаг, агаар орчинд тоос үүсгэх, хөрсний бохирдол, элэгдэл эвдрэл, ойр орчинд дуу чимээ ихсэх, газар ашиглалт, бэлчээр хомсдуулах, байгалийн түүхий эдийн нөөц багасах, үер ус орж голын сайр гольдрил өөрчлөгдөх, уурхайн үйл ажиллагаатай холбоотой осол аваарь гарах, байгалийн төрх байдал ландшафт өөрчөгдөх зэрэг сөрөг нөлөөллүүд их, дунд, бага зэргийн эрчимтэйгээр нөлөөлж болзошгүй байна.

“Тансаг хайрга” уурхайн элс хайрга олборлох төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчлалсан үнэлгээний тайланд дурдсанаар газрын хэвлийг эвдэж өнгөн хөрс хуулах, карьер нээх, овоолго хийх, олборлох, тээвэрлэх, бутлаж ангилан ялгаж угаах үйл ажиллагаар байгаль дэлхий эвдэрч бохирдохоос гадна тоом гэх мэт агаарт дэгдэх, шатах, тослох материал болон шингэн хаягдал хөрсөнд нэвчих замаар бохирдол үүсч эко системд их бага болон болзошгүй сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Бохирдлын эх үүсвэр нь шороон авто зам, бутлан ангилах процесс, түлш шатахууны агуулах, бохирдлын цэг, хатуу хог хаягдал, ахуйн химийн бодис /тоос, бохир ус, угаалгын нунтаг, саван, шампунь/ зэрэг болно.

Харин байгалийн түүхий эрдэс баялагийг бүтээн байгуулалтын ажилд ашиглахад бэлэн болгох, нутгийн иргэдэд ажлын байр шинээр бий болгох зэргээр нийгэмд эерэг нөлөө үзүүлж болохоор байна.

**Хүснэгт 5. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл**

Биосферийн элементүүд	Биосферийн элементүүдэд уулын үйлдвэрлэлийн үзүүлэх нөлөө	Гарч болзошгүй үр дагавар
<b>Хөрс</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөрс хуулалт</li> <li>• Технологийн болон гадаад тээврийн зам байгуулах;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Газрын гадаргуугийн деформаци, хөрсний эдэгдэл, талбайн дүр төрхийн өөрчлөлт</li> <li>• Газрын доорхи усны багасалт</li> </ul>
<b>Ус</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлдвэрийн усны хэрэглээг хянах</li> <li>• Ил задгай талбайд ус тогтох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Газрын доорхи болон гадаргын усны нөөц, горим, чанар өөрчлөгдөх</li> </ul>
<b>Агаар мандал</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Агаарын тоосжилт, хорт хийн тархалт</li> <li>• Тээвэрлэлт, боловсруулалтын явцад тоосжилт үүсэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Тоосжилт</li> <li>• Агаарын бохирдол</li> <li>• Шатах тослох материалаар бохирдох</li> </ul>
<b>Ургамал</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Технологийн болон гадаад тээврийн зам байгуулах;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ургамалын үе доройтох, ховор эмийн ургамалууд устаж үгүй болох</li> </ul>
<b>Амьтан</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Ашиглалтын талбайг ашиглах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Мал амьтан ашиглалтын талбай руу орох, карьерт унах</li> </ul>
<b>Хог хаягдал</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдал их хэмжээгээр гарах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ахуйн бохир усны хадгалалтын найдваргүй байдлаас хөрс, гүний ус бохирдох</li> <li>• Хатуу хог хаягдал үүсч цэгцтэй хадгалахгүй бол салхинд хийсч хөрс, орчин бохирдох үнэр тархах</li> </ul>

### 3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Бид хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, компанийн ажилчид болон нутгийн иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэндэд хохирол учруулахгүй, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах зорилго тавьж ажилладаг болно.

Үүний тулд дараах үндсэн чиглэлүүдэд анхаарч ажиллана. Үүнд:

- Үндсэн болон гэрээт ажилчид, орон нутгийн иргэийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, хянаж ажиллана.
- Монгол улсын хууль, тогтоомж, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг дагаж мөрдөнө.
- Эрүүл, аюулгүй ажлын байр бий болгож, байгаль орчны бохирдол үүсгэхгүй байх нь ажилтан бүрийн үүрэг хариуцлага болгон бүрдүүлнэ.
- Бүх түвшний удирдах ажилтнууд байгаль орчин, хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн манлайлагч байж, ажилчдад үлгэр дуурайлал болно.
- Үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц үр дагаварын тухай нутгийн иргэдээс мэдээлэл өгөх явдлыг урамшуулж хамтран ажиллана.

#### **Эрх зүйн үндэслэл**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг рм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавьж ажилласан.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 31.4 дэх заалт болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.6, 9.7 дахь заалт, 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгов.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг хангаж, явцад нь хяналт тавин ажилласан болно.

## А. Байгаль хамгаалах төлөвлөгөөний биелэлт

Аливаа төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах үйл ажиллагааг зохистойгоор шийдвэрлэх арга зам, түүнд шаардагдах зардлыг хамруулан тусгасан баримт бичгийг **“байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө”** гэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний салшгүй нэг хэсэг бол байгаль хамгаалах төлөвлөгөө бөгөөд энэ төслийн үйл ажиллагааны явцад хүрээлэн буй орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, үүссэн нөлөөллийг бууруулахад барьж ажиллах төлөвлөгөөнд тусгагдсан ажилуудыг бүрэн хэрэгжүүлж шаардлагатай хөрөнгө мөнгийг гарган ажилласан байна.

**I. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

**Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	ХАМРАХ ХҮРЭЭ	НИЙТ ЗАРДАЛ /төг/	БАРИМТЛАХ ХУУЛЬ, ДҮРЭМ СТАНДАРТ
<b>АГААР ОРЧИН</b>				
<b>ДАЙРГА БУТЛАХ, АНГИЛАН ЯЛГАХ ҮЕД ҮҮСЭХ ТООСЖИЛТ</b>	Гадаад тээвэрт явах авто сомасмалуудын тэвшийг бүтээлэгээр бүтээж, асгархаас сэргийлж ажиллав.	Уурхайн бүсэд	40 000	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 /ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/
	Үйлдвэрийн оператор, туслах ажилчдад тоосноос хамгаалах амны хаалт тогтмол зүүлгэж байв.	Бутлуур ангилан ялгах хэсэгт ажиллах ажилчдад	150 000	
	Олборлож буй хайрга нь чийгтэй бутлан ангилах үйлдвэрт орж байсан учираас усалгаа бага хийсэн болно.	Бутлуур ангилан ялгах хэсэгт ажиллах ажилчдад	--*--	
<b>ТЭЭВЭРЛЭЛТЭЭС ҮҮСЭХ ТООСЖИЛТ</b>	Агаарын чанарт байгаль орчин хэмжил зүйн төв лаборатораар хоёр цэгт шинжилгээ хийлгэв.	Уурхайн бүсэд	/зураг/	
<b>ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>				

	Хөрсний чанарт байгаль орчин хэмжил зүйн төв лаборатораар хоёр цэгт шинжилгээ хийлгэв.		/зураг/	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, БОНБУ тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ Энэ стандартаар Монгол орны нутаг дэвсгэр дээрх хөрсөнд агуулагдаж болох бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх (хүлцэх) дээд хэмжээг тогтоох бөгөөд тус стандартад заасан хэмжээнээс давсан тохиолдолд тухайн хөрсийг бохирдолд орсон гэж үзнэ. MNS 5916 : 2008 Газар шорооны ажлын үед үржил, шимт хөрс хуулалт, хадгалалт
<b>ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНТЭЙ ХОЛБООТОЙГООР ХӨРСӨН БҮРХЭВЧ ЭВДРЭЛД ОРОХ, ХОГ ХАЯГДАЛ, ТЕХНИКИЙН ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛААР ХӨРСӨН БҮРХЭВЧ БОХИРДОХ</b>	Машин техникийн засвар үйлчилгээг засвар механикийн хэсэг буюу тогтоосон цэгт хийж гүйцэтгэв.	Уурхайн засварын талбай	--*--	
	Уурхайгаас гарах замыг утгуурт ачигчаар түрж тэгшлэв	0,2 км зам	--*--	
<b>ХАТУУ ШИНГЭН ХОГ ХАЯГДАЛААР ХӨРСНИЙ БОХИРДОЛТ ХОРДОЛТ ҮҮСЭХЭЭС СЭРГИЙЛЭХ</b>	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж талбайн хогийг тогтмол цэвэрлэв.	Уурхайн тосгон	--*--	
	Хатуу, шингэн хаягдлын цэг, ариун цэврийн газрыг ойролцоох, оффис, ажилчдын байр, гал тогоо зэргийг ариутгаж ажиллав.	Уурхайн бүсэд	--*--	
<b>УУРХАЙН ТУСЛАХ БАРИЛГА</b>	Уурхайн тосгоны барилгын гадна хэсэг ойр орчмын хог хаягдалыг цэвэрлэв.	Кемпийн ойр орчим	--*--	

<b>БАЙГУУЛАМЖ</b>	Ахуйн хогийн цэгийг шинээр байгуулав.	Ажилчдын байрны баруун талд	Хаягдал төмөр ашиглав.
<b>УРГАМЛАН НӨМРӨГ</b>			
<b>УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНАА С УРГАМЛАН НӨМРӨГ ДОРЙТОХ</b>	Ажилчдыг тоосноос хамгаалахын тулд мод бутлаг ургамалыг тогтмол услаж байв.	Бутлуурын талбайн ойр орчимд	--*--
	Уурхайн үйл ажиллагаа, овоолгоноос үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийсэн.	Уурхайн бүсэд	--*--
<b>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал 190 000 төгрөг</b>			



## II. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлсэнээр төслөөс үүсэх сөрөг нөлөөлөл түүнийг бууруулж арилгах боломжгүй хүчин зүйлүүд, нөлөөллийн түвшинг төслийн судалгааны ажлын үед тодорхойлоогүй хүчин зүйлс /амьтадын амьдрах орчин, нүүдэл/ тэдгээрийг төслийн хэрэгжих орчны экосистем, биологийн олон янз байдлын хувьд төсөөтэй төсөл хэрэгжих орчныг төлөөлж чадахуйц талбайг сонгон авч хамгааллын арга хэмжээний ажлуудыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлсэнээр орчны нөхцлийг сайжруулахад үндсэн гол зорилго оршино.

**Дүйцүүлэн хамгааллын ажил:** Төслийн байгаль орчны сөрөг нөлөөллийг зохистой бууруулахын тулд нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлага гардаг. 2022 онд төсөл хэрэгжүүлэгч нь дүйцүүлэн хамгаалах ажлыг НБОГ-с Мөнххантайшир ХХК-аар тэрбум мод төслийн хүрээнд шилмүүст мод тарих ажилд 1000.0мян.төг өгсөн болно. /Баримт, Зураг/

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны хүрээнд хийгдэх ажил	Нийт зардал (төг)	Баримтлах хууль, дүрэм, стандарт
<b>НБОГ, МӨНХ ХАНТАЙШИР ХХК хамтрав</b>	Шилмүүст мод тарив	<b>1 000 000</b>	Байгаль орчны багц хуулиуд, MNS 5918:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардалд 2022 онд нийт 1 **000 000** төгрөг төлөвлөж Нийслэлийн байгаль орчны газраас Тэрбум мод төслийн хүрээнд шилмүүст мод тарих ажилыг Мөнх Хантайшир ХХК гүйцэтгэж дээрх төлбөрийг тухайн байгууллагын дансанд шилжүүлэв.

### III. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

#### Хог хаягдал:

##### Ахуйн хог хаягдал:

Ахуйн хатуу хог хаягдлын хувьд жилд 12 тн орчим гарсан. Уурхайн тосгоноос гарах хатуу хог хаягдлыг уурхайн тосгоны хашаанд байрлах хогын цэгт байршуулсан байна. 2022 онд ХУД-н тохьжилт нийтийн аж ахуйн хэлтэстэй гэрээ байгуулан ажиллав.

##### Үйлдвэрийн хог хаягдал:

Элсэн чулуу олборлолтын хаягдлын хэмжээ 0,2 мян.м3 хаягдал шороо хэлбэрээр гарсан бөгөөд хаягдлыг талбай тэгшлэхэд дүүргэгч материал болгон хэрэглэсэн болно.

Үйлдвэрийн явцад шингэн хог хаягдал гараагүй болно.

АРГА ХЭМЖЭЭ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХАМРАХ ХҮРЭЭ	НИЙТ ЗАРДАЛ /төг/	БАРИМТЛАХ ХУУЛЬ, ДҮРЭМ СТАНДАРТ
<b>ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫГ ЗӨӨЖ, ТЭЭВЭРЛЭХ</b>	Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулж байв	Уурхайн ойр орчимд	265 000	Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хууль болон БО багц хуулиуд, холбогдох дүрэм журам стандарт, Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хууль болон БО багц хуулиуд, холбогдох дүрэм журам стандарт, Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хууль болон БО багц хуулиуд, холбогдох дүрэм журам стандарт
<b>ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙГ ХАНГАХ</b>	Уурхайн олборлолтын талбайн ойр орчимд үүссэн ил задгай хаягдсан хог хаягдалыг түүж цэвэрлэж байв	Уурхайн ойр орчимд	Уурхайн ажилчид	
<b>Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний нийт зардал</b>			<b>265 000</b>	

**IV. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

АРГА ХЭМЖЭЭ	ХАМРАХ ХҮРЭЭ	ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	НИЙТ ЗАРДАЛ /төг/	БАРИМТАХ ХУУЛЬ ДҮРЭМ СТАНДАРТ
Байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллав.	Уурхайд үйл ажиллагааны хүрээнд	СУУРЬ ХАНА ХХК	---	БО багц хуулиуд, холбогдох дүрэм журам стандарт, Усны тухай хууль, Байгалийн нөөц ашигласан төлбөрийн тухай хууль, ЗГ-н тогтоол, усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай, бусад холбогдох хууль тогтоол, журам,  Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17), MNS5078-2001, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй”
Ажилчдад ажлын бээлий, хамгаалах хэрэгсэлээр хангав.	Уурхайн ажлын байр	СУУРЬ ХАНА ХХК	57 200	
Уурхайн нийт ажилчдад байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг хамгаалах талаар сургалт хийв.	Уурхайн ажилчид	СУУРЬ ХАНА ХХК	ХАБЭА	
Ажлын байр, зам талбайд ХАБЭА-н тэмдэглэгээ хийв.	Уурхайн талбайн ойр орчимд	СУУРЬ ХАНА ХХК	355 850	
Ажлын хувцас каск хантааз хангав.	Уурхайн ажилчдад	СУУРЬ ХАНА ХХК	367 200	
МХЕГ-аас зохиосон Туул голын сав дагуух түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газарт нөхөн сэргээлт хийх аргачлал сургалтанд хамрагдав.	Уурхайн талбайн ойр орчимд	СУУРЬ ХАНА ХХК	---	
